



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 08 өдөр

Дугаар А/366

Ховд


Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Алтай Таван Богд ууланд 2022 оны 06 дугаар сарын 21-24-ний өдрүүдэд зохион байгуулагдах Монголын өндөр уулын спортын улсын аварга шалгаруулах тэмцээнд Ховд аймгаас оролцох баг тамирчдын хамгаалах хэрэгсэл, тоног төхөөрөмжийн зардалд 900,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэгт зарцуулагдах 900,000 төгрөг (есөн зуун мянга)-ийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2022 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 4.3-д тусгагдсан "Спортын аварга" арга хэмжээнээс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал), Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Б.Даваадорж) нарт тус тус зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Т.Дэлгэрсайхан)-д үүрэг болгосугай.



Б.ДҮГЭРЖАВ